

Хүлэрт намгийн төсөл

Төслийн хүрээнд яг юу хийсэн бэ?

“Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах байгальд суурилсан шийдэл” төслийн баг Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын хүлэрт намгийн тархац, шинж чанарын талаарх судалгааг 2021 оноос хойш хийж зураглалыг шинэчиллээ. Ингэснээр нутгийн иргэдэд хүлэрт намгийн ач холбогдлыг ойлгуулж, нүүдлийн соёл уламжлалыг тэжээн тэтгэгч байгалийг бүрэн бүтэн авч үлдэх, урт хугацаанд тогтвортой, зөв зохистой ашиглах, хамгаалах бодитой хамгаалах шинжлэх ухааны үндэслэл бий болох юм.




The Nature
Conservancy
Mongolia

©Erdenebulgan Photographer

■ Судалгааны аргачлал юу байв?

Баянзүрх сум дахь хүлэрт намгийн тархцыг тодорхойлохдоо, 200 цэгт үнэлгээ хийж, ургамал болон хөрсний дээж авч гүйцэтгэлээ. Түүнчлэн хиймэл дагуулын мэдээ, үүлэн тооцоолол зэрэг шинэлэг аргуудыг туршиж мөн цаашид тооцооллын аргыг сайжруулахаар хээрийн судалгаа нэмэлтээр хийж гүйцэтгэлээ.



Хүлэрт намаг Баянзүрх сумын 62,600 га талбай буюу нийт газар нутгийн 14.2%-ийг эзэлж байна. 2024 он.

Хүлэрт намгийг яагаад хамгаалах ёстой юм?

Монгол Улсад:

■ 1992-2020 онд дэлхийн дулааралд гол нөлөө үзүүлэгч нүүрсхүчлийн хийн агууламж 16.5 хувиар, метаны агууламж 8.8 хувиар тус тус нэмэгджээ.

■ Улмаар агаарын дундаж хэм сүүлийн 80 гаруй жилд 2.25 хэмээр буюу дэлхийн дунджаас даруй 2.5 дахин нэмэгдэж хур тунадасын хэмжээ жил бүр 8 хувиар багассан.

■ Бэлчээрийн доройтол, цөлжилт нэмэгдэж Монгол орны газар нутгийн 76.8 хувь нь их, бага хэмжээгээр цөлжсөн.

■ Байгалийн гамшигт үзэгдэл сүүлийн 20 жилд 2 дахин нэмэгдсэн.

■ Малын тоо толгой сүүлийн 30 жилд нэмэгдсээр бэлчээрийн даацаас 3 дахин хэтэрч хөрсний чанарыг муутгасаар байна.

Харин хүлэрт намаг нь дэлхийн дулаарлын хурдасгуур гэгдэх хүлэмжийн хийг агаар мандлаас шингээх асар их нөөц бололцоотой билээ.

Хүлэрт намгийн үүрэг, ач холбогдол

- Усны эх үүсвэрийг хангах;
- Үерийн усыг шингээх;
- Хүлэмжийн хийг шингээх;
- Уур амьсгалын өөрчлөлтийг намжаах;

- Биологийн олон янз байдлыг хамгаалах;
- Цэвдэг хайлахаас хамгаалах
- Ой хээрийн түймрийн тархалтыг сааруулах;
- Эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх гэх зэрэг олон талын ач холбогдолтой.

Харамсалтай нь хүлэрт намаг Монгол Улсын нутаг дэвсгэрийн 1.7% хүрэхгүй талбайг эзэлдэг бөгөөд сүүлийн 10 жилд 2 дахин багасчээ.

Цаашид яах вэ?

Төслийн хүрээнд Баянзүрх сумаас гадна Монгол орны хүлэрт намгийн тархцыг дахин үнэлж, зураглалыг сайжрууллаа.

1950-1970 онд
Монгол Улсын



буюу нийт газар нутгийн



2

орчим хувийг

хүлэрт намаг эзэлж байсан бол



2015, 2016 оны
шинэчилсэн судалгаагаар

↓ 1.7%
болж буурсан

/Эх сурвалж: Минаева нар, 1970; 2016 он/

Төслийн баг мал бэлчээрлэлтийн эрчим болон улирлын ашиглалтын хэв маяг нь хүлэрт намаг ба түүний нүүрстөрөгчийн нөөцөд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлохоор GPS-ийн тусламжтай хяналт, ажиглалтыг үргэлжлүүлэн хийж байна.

Малчдын нөхөрлөлүүдтэй хамтран хүлэрт намаг орчмын бэлчээр нутагт ээлтэй бэлчээрийн менежментийн хувилбарыг туршиж үр ашгийг нь судлана. Мөн нөхөрлөлүүдийн засаглалын чадавх, байгалийн нөөцийн менежментийг сайжруулах замаар байгаль хамгаалалд хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Бид юу хийж чадах вэ?

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах байгальд суурилсан шийдэл гэдэг нь хөдөө аж ахуйн газар, ой, үетэнт хээр болон ус намгархаг газрын нүүрстөрөгчийн нөөцийг нэмэгдүүлэх, мөн хүлэмжийн хийн ялгаралтаас зайлсхийх **ХАМГААЛАЛ, МЕНЕЖМЕНТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ** гэсэн цогц үйл ажиллагаа юм.

Үүнийг хэрэгжүүлснээр Баянзүрх сум жилдээ 2,244,000 тонн нүүрсхүчлийн хий шингээх боломжтой.

Монгол Улсын хүлээсэн үүрэг амлалтууд

Монгол Улс байгаль хамгааллын эртний түүхтэй орон бөгөөд биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлтийг хамарсан олон улсын бүх үндсэн гэрээ хэлэлцээрт нэгдэн орсноос гадна Засгийн газрын урт хугацааны бодлого төлөвлөлтдөө ч байгаль хамгааллыг тод томруунаар багтаасан байдаг.

“Алсын хараа-2050” Зорилт 6.1:

Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь конвенц:

2030 онд хүлэмжийн хийн ялгарлыг ердийн нөхцөлтэй харьцуулахад 22.7 хувь бууруулна.

“Ногоон хөгжлийн бодлого” Стратегийн зорилт:

2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

Хуурай газрын

3%

эзэлдэг ч,

нүүрстөрөгчийн нийт нөөцийн

30

орчим хувийг
дангаар бүрдүүлдэг.

Өөрийн жингээс

20

дахин их

хэмжээний ус хадгалдаг.

15 см
зузаантай

хүлэрт давхарга нь халуун орны
нэг га ой модоос ч их нүүрстөрөгч
агуулдаг.

Хүлэрт намгийн ус

90%

10%

хатуу биет байдаг.



Төллүүр тарна, Беллардийн бушилз,
Намгийн Дүндэггарав тэргүүтэй
ховор ургамалтай.

Таны оролцоо:

- Бэлчээрээ сэлгэн нүүдэллэх
- Бэлчээрийн даац хэтрүүлэхгүй байх
- Хүлэрт намгийг шатаахгүй байх
- Газар ашиглах зорилгоор хүлэрт намгийн усыг шавхахгүй байх
- Газар тариаланд ашиглахгүй байх.

